

УСНЫ ГАЗРЫН 2024-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БҮТЭЦ, АГУУЛГА

Бүлэг 1. Нийтлэг үндэслэл	2-3
Бүлэг 2. Мандатын шинжилгээ	3-8
Бүлэг 3. Алсын хараа	9
Бүлэг 4. Эрхэм зорилго	9
Бүлэг 5. Орчны шинжилгээ	9-15
Бүлэг 6. Стратегийн зорилго.....	15
Бүлэг 7. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги.....	15-21
Бүлэг 8. Стратегийн зорилго ба Усны газрын нэгж, байгууллагын бүтцийн уялдаа, зураглал.....	22-24
Бүлэг 9. Хавсралт мэдээллийн жагсаалт	25

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их хурлын 2010 оны 07 дугаар сарын 15-ны өдрийн 48 дугаар тогтоолоор “Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”-ыг, 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-ыг баталж, уг баримт бичигт нийцүүлэн Улсын Их хурлаас 2021 оны 106 дугаар тогтоолоор “Шинэ сэргэлтийн бодлого”, 2024 оны 21 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг тус тус баталж, хөгжлийн бодлогын баримт бичгүүдийн зорилго, зорилтуудыг тодорхойлсон.

Усны нөөцийн салбарт өнөөгийн байдлаар усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбоотой харилцааг 10 хуулиар нарийвчлан зохицуулахаас гадна олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай конвенцод Монгол улс 1997 оны 06 дугаар сарын 05-ны өдөр нэгдсэн орсон, түүнчлэн Биологийн олон янз байдлын тухай конвенц, Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх нэгдсэн үндэсний байгууллагын суурь конвенц, Усны нөөцийг ашиглах, хамгаалах асуудлаар ОХУ, БНХАУ зэрэг хөрш орнуудтай хамтран ажиллах гэрээнүүдэд нэгдсэн.

Усны нөөцийн салбарын ирэх 4 жилийн стратеги төлөвлөгөөнд байгаль орчныг хамгаалах, усны нөөцийн талаарх хууль тогтоомж, Монгол улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол Улсын хөгжлийн урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлогууд, Олон улсын гэрээ, конвенцын хүрээнд Монгол улсын хүлээсэн үүрэг, хариуцлагыг хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд тулгамдсан асуудлыг шийдвэрлэхэд чиглэсэн зорилго, стратегийг боловсруулж тусгасан.

2017 онд шинэчлэн батлагдсан Төрийн албаны тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт “Төсвийн ерөнхийлөн захирагч хууль тогтоомжид нийцүүлэн харьяа байгууллагын дөрвөн жилийн стратеги төлөвлөгөөг боловсруулан баталж, хэрэгжилтийг хариуцан зохион байгуулна” гэж заасныг үндэслэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Усны газрын 2024-2028 оны стратеги төлөвлөгөөг боловсруулсан.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахдаа Засгийн газрын 2020 оны 216 дугаар тогтоолоор баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах, батлах, хэрэгжилтийг хангах журам”, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2020 оны 100 дугаар тушаалаар баталсан “Стратеги төлөвлөгөө боловсруулах аргачлал”, “Стратеги төлөвлөгөөний загвар”-ыг баримталсан.

Стратеги төлөвлөгөөнд Засгийн газрын өмнөх 4 жилийн үйл ажиллагааны хөтөлбөрт байгаль орчин, усны нөөцийн чиглэлээр дэвшүүлсэн зорилтууд болон Усны газрын 2021-2024 оны Стратеги төлөвлөгөөний биелэлтэд хийсэн дүн шинжилгээ, урт, дунд, богино хугацааны бодлогын баримт бичгүүдэд дэвшүүлсэн зорилтуудын үр дүн, Усны газрын хуулиар хүлээсэн чиг үүргийг хэрэгжүүлэх, төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний үр нөлөө, үр дүнг харгалзан цаашид чиг үүргийг бүрэн хэрэгжүүлэхтэй холбоотой үйл ажиллагааг уялдуулан тусгасан.

Энэхүү төлөвлөгөөг “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д тусгасан усны нөөцтэй холбоотой үндсэн чиглэл, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баримтлан “Усны нөөцийг бохирдол, хомстлоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, салбар дундын зохицуулалтаар хангана” ерөнхий чиг үүргийн хүрээнд 4 үндсэн чиг үүрэг, 11 зорилт, 49 арга хэмжээг 4 жилийн хугацаанд хэрэгжүүлж, төсвийн ерөнхийлөн захирагчид нийлүүлнэ.

Дээрх зорилт, стратеги арга хэмжээг хэрэгжүүлэхдээ байгууллагын хөрөнгө, санхүүгийн болон хүний нөөцийг хамгийн оновчтой байдлаар хуваарилан зарцуулж, дэвшүүлсэн зорилго, зорилтуудын хэрэгжилтийг хангахаар төлөвлөсөн болно.

ХОЁР. МАНДАТЫН ШИНЖИЛГЭЭ

Усны газар нь Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын өмнө усны нөөц, түүний сав газрыг хамгаалах, нөхөн сэргээх, бохирдохоос урьдчилан сэргийлэх, зохистой ашиглуулах, усны талаарх хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх, мэдээллийн тогтолцоог бүрдүүлэх, мэдээллийн нэгдсэн санг бий болгож, мэдээллийг шуурхай хүргэх үүрэг, хариуцлагыг хүлээнэ.

Усны газрын мандатыг тодорхойлохдоо Монгол Улсын Үндсэн хууль болон Усны салбарын шууд хамаарах 13 хуулийн хүрээнд усны салбарын байгууллагуудад хуулиар олгосон усны нөөцийн нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх үндсэн чиг үүргүүдийг хамруулан дор дурдсан хүснэгтээр тодорхойлов.

Хүснэгт 1. Мандатын шинжилгээний хүснэгт

Салбарын үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа хуулийн тоо		50
Үүнээс:	Тухайн салбарын хуулийн тоо	10
	Олон улсын гэрээ, конвенцын тоо	3
	Нийтлэг мөрддөг хуулийн тоо	37
Салбарын хуулиуд	1.	Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
	2.	Байгаль орчныг хамгаалах тухай хууль
	3.	Усны тухай хууль /Шинэчилсэн найруулга/
	4.	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
	5.	Гол мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хууль
	6.	Гол, мөрний урсац бүрэлдэх эх, усны сан бүхий газрын хамгаалалтын бүс, ойн сан бүхий газарт ашигт малтмал хайх, ашиглахыг хориглох тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай
	7.	Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хууль
	8.	Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль (Шинэчилсэн найруулга)
	9.	Хот, суурины ус хангамж, ариутгах татуургын ашиглалтын тухай
	10.	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хууль
Олон улсын гэрээ, конвенц	1.	Биологийн олон янз байдлын тухай конвенц Convention on Biological Diversity
	2.	Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар, ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Рамсарын конвенц Convention on Wetlands of Int'l importance especially as waterfowl habitat
	3.	Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх нэгдсэн үндэсний байгууллагын суурь конвенц United Nations Framework Convention on Climate Change
	1.	Монгол Улсын Үндсэн хууль

Нийтлэг мөрддөг хуулиуд	2.	Монгол Улсын Засгийн газрын тухай хууль
	3.	Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай хууль
	4.	Хууль тогтоомжийн тухай хууль
	5.	Захиргааны ерөнхий хууль
	6.	Төрийн албаны тухай хууль
	7.	Төсвийн тухай хууль
	8.	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
	9.	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль
	10.	Төрийн хяналт шалгалтын тухай хууль
	11.	Бүсчилсэн хөгжлийн удирдлага зохицуулалтын тухай хууль
	12.	Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль
	13.	Зөвшөөрлийн тухай хууль
	14.	Зөрчлийн тухай хууль
	15.	Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
	16.	Шинжлэх ухаан, технологийн тухай хууль (шинэчилсэн найруулга)
	17.	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	18.	Олон улсын гэрээний тухай хууль
	19.	Төр, хувийн хэвшлийн түншлэлийн тухай хууль
	20.	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
	21.	Цахим гарын үсгийн тухай хууль
	22.	Кибер аюулгүй байдлын тухай
	23.	Авлигын эсрэг хууль
	24.	Архив бичиг хэрэг эрхлэлтийн тухай
	25.	Хувь хүний орлогын албан татварын тухай
	26.	Гамшгаас хамгаалах тухай
	27.	Мэргэжлийн нэгдсэн холбооны эрх зүйн байдлын тухай хууль
	28.	Эрүүгийн хууль
	29.	Хэмжил зүйн тухай хууль
	30.	Төрийн болон албаны нууцын тухай хууль
	31.	Байгууллагын нууцын тухай хууль
	32.	Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль
	33.	Ус цаг уур, орчны хяналт шинжилгээний тухай хууль
	34.	Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль
	35.	Усан замын тээврийн тухай хууль
	36.	Газрын тухай хууль
	37.	Тариалангийн тухай хууль

Хүснэгт 2. Мандатын шинжилгээ

Ерөнхий чиг үүрэг: Усны нөөцийг бохирдол, хомстлоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, салбар дундын зохицуулалтаар хангана.		
Үндсэн чиг үүрэг	Дэд чиг үүрэг	Хамтран хэрэгжүүлэх чиг үүрэг, оролцогчид
ҮЧҮ-1: Усны нөөцийг судалж тогтоох, хамгаалах, нөхөн сэргээх, хуримтлуулах, усны нөөцийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулах, хяналт тавих, сав газрын менежментийн тогтолцоог бэхжүүлж, усны мега төслийг хэрэгжүүлэх;	1.1.Усны нөөцийг зохистой ашиглах, усны талаарх бодлого, хууль тогтоомжийг хэрэгжүүлэх. /АЭБТХ-ийн 7 дугаар зүйл/	БОУАӨЯ, ХЗДХЯ, ГХЯ, СЯ, СГЗ, Холбогдох бусад яамд, агентлаг
	1.2.Улсын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөний төсөл боловсруулах, уг төлөвлөгөөний хэрэгжилтийг зохион байгуулах. /УТХ-ийн 16 ¹ .4.1/	
	1.3.Усны сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг ашиглах боломжит нөөцийн хэмжээг үндэслэн боловсруулах. /УТХ-ийн 4.7/	
	1.4.Хилийн усны гэрээ, хэлэлцээр болон бусад холбогдох конвенцын хэрэгжилтийг хангах. /УТХ-ийн 10.1.7/	
	1.5.Усны экологи-эдийн засгийн үнэлгээ, усны үнэ, тариф тогтоох чиглэлээр судалгаа хийх аргачлал, зааврыг боловсруулах, усны нөөцөд учруулсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр тооцох. /УТХ-ийн 16 ¹ .4.7/	
	1.6.Усны ашиглах боломжит нөөцийн хэмжээг сав газрын хэмжээнд ашиглалтын зориулалт бүрээр тогтоон боловсруулж мөрдүүлэх, хяналт тавих. /УТХ-ийн 16 ¹ .4.3/	
	1.7.Гадаргын болон газрын доорх уснаас ашиглах боломжит нөөцийн дээд хязгаарыг тогтоох санал боловсруулах, мөрдүүлэх, хяналт тавих. /УТХ-ийн 16 ¹ .4.4/	
	1.8.Усны хайгуул, зураг төсөл, судалгааны төлөвлөгөө боловсруулах, хэрэгжүүлэх, хайгуул, судалгааны ажлын явцад хяналт тавих. /УТХ-ийн 16 ¹ .4.2/	
	1.9.Улсын усны тоо бүртгэл, статистикийн мэдээллийг нэгтгэн боловсруулах. /УТХ-ийн 16 ¹ .4.6/	
	1.10.Усны тоо бүртгэлийг жил бүр сав газрын хэмжээнд нутгийн захиргааны байгууллагатай хамтран зохион байгуулж, усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад тайлагнах. /УТХ-ийн 17.1.4/	
	1.11.Аж ахуйн нэгжийн өөрийн хөрөнгөөр олж илрүүлсэн усны ашиглах боломжит нөөц нь тухайн хэрэгжүүлэх төслийн усны хэрэгцээг бүрэн хангаж, илүү гарах нөхцөлд бусад аж ахуйн нэгжийн хэрэгцээнд ашиглуулах нөхцөлд дүгнэлт гаргах. /УТХ-ийн 28.15/	
	1.12.Бэлчээрийн усжуулалт, услалтын систем барих ажлын хайгуул, судалгаа, зураг төсөлд дүгнэлт гаргах. /УТХ-ийн 16 ¹ .4.13/	

ҮЧҮ-2: Усны нөөцийг зохистой ашиглах бодлогын хэрэгжилтийг хангах, усны нөөцийн дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, ус хэмнэлтийг дэмжиж, мэргэжил арга зүйгээр хангах;	2.1.Усны нөөц ашиглалтын тайланг улсын хэмжээнд нэгтгэн гаргах. /УТХ-ийн 16¹.4.6/ 2.2.Голын голдирлыг өөрчлөх, урсцад тохируулга хийх, шилжүүлэн ашиглах, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд дүгнэлт гаргах. /УТХ-ийн 16¹.4.9/ 2.3.Стратегийн томоохон орд газарт цооног өрөмдөх, ус ашиглах судалгаа хийхэд дүгнэлт гаргах. /УТХ-ийн 16¹.4.10/ 2.4.Хоногт 100 шоометрээс их ус ашиглах, эрчим хүч, усан тээврийн зориулалтаар ашиглуулах, хүн амын төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэрийн ус хангагч байгууллагад ус ашиглуулах дүгнэлтийг гаргана. /УТХ-ийн 28.4, 28.7/ 2.5.Усны тухай хуулийн 28.4-т заасны дагуу гаргасан ус ашиглах дүгнэлт, 28.6-д заасан ус ашиглах зөвшөөрөл, 28.11-д заасан гэрээнд хяналт тавих. /УТХ-ийн 16¹.4.9/ 2.6.Ган, цөлжилт, хуурайшилтын үед усны нөөц хомсдох, бохирдсон тохиолдолд тухайн сав газарт ус ашиглагчийн ашиглах усыг хуваарилах, хязгаарлах, ус, түүний орчныг нөхөн сэргээх зорилгоор ус ашиглахыг тодорхой хугацаагаар түр хориглох. /УТХ-ийн 16¹.4.12/ 2.7.Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулахтай холбогдсон журам, зааврын хэрэгжилтийг хангаж ажиллах. /АЭБТХ-ийн 7 дугаар зүйл/	БОУАӨЯ, ХЗДХЯ, ХББОСЯ, СЯ, СГЗ, АНБОГ, АНЗД, СДЗД, УМБ, ААНБ, Холбогдох бусад яамд, агентлаг
ҮЧҮ-3: Газрын доорх усны нөөц, чанарын хяналт шинжилгээ, гадаргын болон газрын доорх усны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ хийх, усны бохирдлыг бууруулах, ус бохирдуулсны төлбөрийн тухай тухай хуулийг хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах замаар усны нөөцийг хомсгож, бохирдохоос сэргийлэх;	3.1.Усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах зорилго бүхий усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээг зохион байгуулж ажиллуулах. /УТХ-ийн 6.1/ 3.2.Усны сан бүхий газар, хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүсийн дэглэмийн хэрэгжилтэд хяналт тавих. /УТХ-ийн 22/ 3.3.Ус бохирдуулсны төлбөр төлөгчийн гаргасан хаягдал усанд төлбөр ногдуулна. /УБТТХ-ийн 5.1/ 3.4.Ус хэмнэх, хаягдал усыг цэвэрлэх, дахин ашиглах техникийн нөхцөл, стандартыг дэвшилтэт технологи, шинжлэх ухааны ололтод тулгуурлан боловсруулж, хэрэгжилтэд хяналт тавих. /УТХ-ийн 16¹.4.8/ 3.5.Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг хоногт 50 шоометрээс их, эсхүл аюултай бохирдуулах бодис агуулсан хаягдал ус гаргадаг ус бохирдуулагчид ус ашиглуулах дүгнэлт гаргах. /УТХ-ийн 24.2/ 3.6.Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлал, зуслан, орон сууц, олон нийтийн бүс, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой	БОУАӨЯ, ХЗДХЯ, ХББОСЯ, СЯ, СГЗ, АНБОГ, АНЗД, СДЗД, УМБ, ААНБ, Холбогдох бусад яамд, агентлаг

	болон энгийн хамгаалалтын бүс, хүн амын унд, ахуйн усан хангамжийн тэжээгдлийн мужийн дотор, ашигт малтмалын нөөц нь тогтоогдсон болон бусад хууль тогтоомжоор хориглосон газарт энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах байгууламж байгуулахыг хориглох. /ХХТХ-ийн 16.8/	
	3.7.Усны хяналтын төв лабораторийн тасралтгүй үйл ажиллагааг хэрэгжүүлж, усны бохирдлыг бууруулах суурь мэдээллийг бүрдүүлэх, лабораторийн шинжилгээ хийх. /ХЗТХ-ийн 22.1.1/	
	3.8.Усны чанарыг бохирдлын индексээр үнэлэх. /ХЗТХ-ийн 22.1.1/	
ҮЧҮ-4: Салбарын нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг хангаж, үйл ажиллагааны менежмент, хүний нөөц, гадаад хамтын ажиллагаа, санхүү, хөрөнгө оруулалт, хууль эрх зүй, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, цахимжилт, дотоод хяналт, шинжилгээ болон төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах.	4.1.Ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллагыг усны талаарх мэргэжил, арга зүйн нэгдсэн удирдлагаар хангана. /УТХ-ийн 16 ¹ .2/	БОУАӨЯ, ХЗДХЯ, СГЗ, АНБОГ, АНЗД, СДЗД, УМБ, ААНБ, Холбогдох бусад яамд, агентлаг
	4.2.Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, хөдөө аж ахуйн мэргэжилтэн болон сум, дүүргийн байгаль орчны хяналтын улсын байцаагч, байгаль хамгаалагчийг усны талаарх мэргэжил, арга зүйн удирдлагаар хангана. /УТХ-ийн 16 ¹ .3/	
	4.3.Усны мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн улсын усны төлөв байдлын тайланг жил бүр гаргах. /УТХ-ийн 7.4/	
	4.4.Улсын усны мэдээллийн санг бүрдүүлж хөтлөх, усны төлөв байдалтай холбоотой мэдээллээр иргэн, хуулийн этгээдийг хангах. /УТХ-ийн 16 ¹ .4.5/	
	4.5.Мэдээллийн системийн найдвартай, аюулгүй, тасралтгүй ажиллагааг хангах. /НМИТБТХ-ийн 34.1.1/	
	4.6.Үйл ажиллагаа, үйлчилгээг цахимжуулах ба нээлттэй өгөгдлийн хүртээмжийг нэмэгдүүлэх /НМИТБТХ-ийн 34.1.4/	
	4.7.Хууль эрх зүй, хөгжлийн бодлого, хөтөлбөрийн хэрэгжилтийг нэгдсэн удирдлагаар хангаж, үр дүнг тооцох /АЭБТХ-ийн 7 дугаар зүйл/	
	4.8. Хүний нөөцийн бодлогыг тодорхойлж, төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах./ТАТХ-ийн 27, 55.3/	
	4.9.Төсвийн шууд захирагчийн төсвийн төсөл, хөтөлбөрийг төлөвлөх, бүтээгдэхүүн нийлүүлэлтийн төлөвлөлтийг зохион байгуулж, байгууллагын санхүү, хөрөнгө оруулалтын удирдлага, зохицуулалт, төсвийн ил тод байдлыг хангах	
	4.10. Байгууллагын өмч, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэл хяналтыг сайжруулах, өргөтгөл, шинэчлэлт хийх	

ГУРАВ. АЛСЫН ХАРАА

Монгол Улсын усны нөөцийг хамгаалж, байгальд ээлтэй ус ашиглалт болон дахин ашиглалтыг хөгжүүлэн, тогтвортой менежментийн бодлогоор экосистем ба эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах үндэсний тэргүүлэгч байгууллага болно.

ДӨРӨВ. ЭРХЭМ ЗОРИЛГО

Монгол Улсын усны нөөцийг нэгдсэн менежментийн зарчмыг хэрэгжүүлж, тогтвортой хөгжлийн зорилтод нийцүүлэн иргэд, аж ахуйн нэгжийг баталгаат, хүртээмжтэй усаар хангах, усны хэмнэлттэй, үр ашигтай хэрэглээг төлөвшүүлэхэд чиглэгдэнэ.

ТАВ. ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭ

5.1. Усны салбарын нөхцөл байдал

5.1.1. Уур амьсгалын өөрчлөлт

Монгол Улс газар зүйн байршил, цаг уурын онцлог, нүүдлийн соёл зэргээс хамааран нийгэм, эдийн засгийн хувьд уур амьсгалын өөрчлөлтөд эмзэг, өртөмтгий, эрсдэлтэй орны тоонд ордог. Монгол оронд уур амьсгалын өөрчлөлт дэлхийн дунджаас илүү эрчимтэй явагдаж байгаа нь дараах байдлаар илэрч байна. Тухайлбал: Манай орны жилийн агаарын температур сүүлийн 85 жилд дунджаар 2.5°C хэмээр, зарим нутагт 3-3.5°C-ээр дулаарч, хуурайших хандлага давамгайлж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөгөөр Монгол орны хэмжээнд сүүлийн 10 жилд нийт нуурын тоо 132-оор буурч ширгэн, нуурын усан гадаргын талбай 50.3 км²- аар багассан бол мөсөн голын талбай сүүлийн 80 жилд 40-47 хувиар багасаж, нийт нутаг дэвсгэрийн 76.8 хувь нь цөлжилт, газрын доройтолд өртсөн байна. Манай улсад 1990-2023 оны хооронд тохиолдсон ус, цаг агаарын гаралтай аюулт, гамшигт үзэгдэл жилд дунджаар 60 удаа байсан бол сүүлийн 10 жилд 98 болж нэмэгдэж, жил бүр ойролцоогоор 50-70 орчим тэрбум төгрөгийн хохирол учирч хохирлын хэмжээ 10-14 дахин нэмэгдсэн байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллөөс үүдэлтэй ган гачиг, зуд турхнаас шалтгаалан хөдөө орон нутгийн иргэдийн хот суурин газар руу шилжих шилжилт хөдөлгөөн эрчимжиж, төвлөрлийг бий болгосноор Улаанбаатар хотын агаарын бохирдол, автозамын түгжрэл, төлөвлөлтгүй газар ашиглалт, ажилгүйдэл ядуурал нэмэгдэх, сургууль, цэцэрлэг, эмнэлгийн үйлчилгээний чанар хүртээмж буурах зэргээр нийгэм, эдийн засагт сөрөг нөлөө үзүүлэх шалтгаан болж байна.

Монгол Улсын хүлэмжийн хийн нийт ялгарал 1990 оноос хойш 82.1%-иар нэмэгдсэн нь дээрх хүн амын төвлөрөл нягтшил, үйлдвэрлэл хэрэглээ, малын тоо толгойн өсөлттэй холбоотой бөгөөд нийт хүлэмжийн хийн ялгарлын 51.1%-ийг хөдөө аж ахуйн салбар, 44.7%-ийг эрчим хүчний салбар, үлдсэн хувийг аж үйлдвэр, барилга, зам тээвэр болон хог хаягдлын салбар ялгаруулж байна.

Монгол Улс Парисын хэлэлцээрээр хүлээсэн үүргийн дагуу дээрх салбаруудад хүлэмжийн хийн ялгарлыг 2035 он хүртэл 30.3%-иар бууруулж, шингээлтийг нэмэгдүүлэх үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмрийн зорилтыг Засгийн газрын 2025 оны 91 дүгээр тогтоолоор шинэчлэн баталсан.

2024 онд НҮБ-ын Хөгжлийн хөтөлбөрийн дэмжлэгээр Парисын хэлэлцээрээр хүлээсэн ҮТХН (NDC2.0)-н 2020-2024 оны хэрэгжилтийг үнэлсэн. Тус үнэлгээгээр 2020-2024 онд 7.5 сая тн CO₂ -ийн ялгаруулалтыг бууруулах зорилтын хэрэгжилт 39.7%-тай үнэлэгдсэн байна.

Энэ нь бага нүүрстөрөгч бүхий цэвэр үйлдвэрлэл, хэрэглээг дэмжих эрхзүйн орчин дутмаг, салбар дундын зохицуулалт тодорхойгүй, уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох арга хэмжээг шинжлэх ухааны үндэстэйгээр хэрэгжүүлэх цогц судалгаа, өгөгдөл, мэдээллийн сан байхгүй зэргээс шалтгаалан хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, шингээлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх, зах зээлд суурилсан арга хэрэгслийг нэвтрүүлэх олон улсын туршлагыг хэрэгжүүлэхэд тулгамдсан асуудал болж байгааг харуулж байна.

Уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөнөөс сэргийлэх эрсдэл, эмзэг байдлын үнэлгээнд үндэслэн дасан зохицох арга хэмжээг төлөвлөх, шаардагдах санхүүжилтийг олон талын эх үүсвэрээс шийдвэрлэх, ногоон санхүүжилтийн тогтолцоог бүрдүүлэх, уур амьсгалын санхүүжилтийн олон улсын механизмуудыг хөгжүүлэх, энэ хүрээнд карбон кредитийг бүртгэх, хянан баталгаажуулах, арилжих, шилжүүлэх, тохируулга хийх, тайлагнах, мэдээллийн сан үүсгэх эрх бүхий Үндэсний зохицуулагч байгууллагыг томилох, салбар дундын уялдаа холбоог хангах, Уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицох чадамжийг нэмэгдүүлэхэд цөлжилт, газрын доройтлыг бууруулахтай холбогдсон газрын харилцааны үйл ажиллагааг байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн асуудалтай цогцоор авч үзэх бодлого зохицуулалтыг хэрэгжүүлэх, эрх зүйн үндсийг бүрдүүлэх шаардлагатай байна.

5.1.2. Усны нөөц

Монгол Улсын Их Хурлаар 2012 онд баталсан Усны тухай хуулиар усны нөөцийг стратегийн үнэт баялаг болохыг тодорхойлж, усыг экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулахгүйгээр ашиглаж болох боломжит нөөцийн хэмжээнд зөвшөөрлийн механизмаар дамжуулан үр ашигтай, хэмнэлттэй ашиглах зарчмыг тогтоосон. Мөн Монгол орны нутаг дэвсгэрийг усны сав газарт хуваан, сав газрын захиргаадыг байгуулан, усны нөөцийн хамгаалалт, ашиглалтыг тухайн сав газарт менежментийн төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх замаар зохицуулах эрх зүйн үндэс бүрдсэн.

Усны нөөцийг боломжит нөөцийн хэмжээнд хэмнэлттэй, үр ашигтай ашиглах, нэгдсэн бодлого зохицуулалтаар хангах, усны талаарх бодлого, хөтөлбөр, хууль тогтоомжийг боловсронгуй болгох, тэдгээрийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, зохицуулах, мэргэжил, арга зүйн удирдлагаар хангах, зөвлөгөө өгөх бодлогыг баримтлан ажиллаж байна.

Монгол Улсын хувьд гандуу хуурай бүс нутагт оршдог, уур амьсгалын өөрчлөлтийн сөрөг нөлөөнд дэлхийн дунджаас 2-3 дахин их өртөгдөж, цэнгэг усны нөөцийн хомстолд орох эрсдэлтэй улс орнуудын нэг. Монгол орны усны нийт нөөц 564.8 км³ бөгөөд үүнээс нуур, тойром 500.0 км³, гол мөрөн 34.6 км³, мөстөл 19.4 км³, газрын доорх ус 10.8 км³ нөөцийг бүрдүүлдэг бөгөөд нөөц нь нутаг дэвсгэрийн хэмжээнд жигд бус тархсан байдаг.

Монгол орны хэмжээнд усны менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх бүхий усны 29 сав газарт хувааж, усны 21 Сав газрын захиргаанд 195 албан хаагч, сав газрын талуудын оролцооны зөвлөлд нийт 1000 гаруй гишүүд ажиллаж байна.

Сав газрын захиргаадыг байгуулснаар усны салбар орон нутагт эзэнтэй болж, усны ашиглалт, хамгаалалт сайжирч, үрэлгэн хэрэглээг багасгаж, орон нутгийн төсвийн орлого хэд дахин нэмэгдсэн.

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн дагуу усны нөөцийн төлбөрт 2020-2024 онд жил бүр 42-86 тэрбум төгрөгийн орлого орон нутгийн төсөвт төвлөрч байна. Тухайлбал: 2024 оны усны нөөц ашигласны төлбөрт 86.9 тэрбум төгрөг төвлөрсөн байна. Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлогын 35-аас доошгүй хувийг ус, усан орчныг

хамгаалах, нөөцийг нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах гэсэн хуулийн зохицуулалтын хэрэгжилт хангалтгүй хэвээр байна.

Цаашид усны нөөц бүрэлдэх, тэжээгдэх нөхцөл нь засаг захиргааны нэгжийн хилээр бус, газарзүйн хил буюу усны сав газрын хилээр зааглагддаг тул ус, усан орчныг хамгаалах, нөхөн сэргээх ажлыг сав газрын хэмжээнд явуулах шаардлагын үүднээс нөөц ашигласны төлбөрийн тодорхой хувийг улсын төсөвт төвлөрүүлж, улсын хэмжээнд хамгааллын үйл ажиллагаа явуулахаар дахин хуваарилах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлэх шаардлагатай байна.

Ус ашиглагч, хэрэглэгч иргэн аж ахуйн нэгж байгууллагуудын усны хэрэглээг бодитой тооцох, үргүй зардлыг бууруулах, хяналттай, ил тод болгох зорилгоор ус хангамжийн эх үүсвэрийг тоолууржуулах ажлыг холбогдох байгууллагатай хамтран Улаанбаатар хотод 90 орчим, Дархан, Эрдэнэт хотуудад 70 гаруй, аймгийн төвүүдэд 60 гаруй хувьтай гүйцэтгээд байна.

Хүн амын унд ахуй, хөдөө аж ахуйн салбарын ус олборлолтын хэмжээг холбогдох нормын дагуу Үндэсний статистикийн хорооны дүн мэдээлэлд тулгуурлан тооцож байна. Харин үйлдвэрлэл, барилга, ногоон байгууламж, үйлчилгээний зориулалтаар олборлосон усны хэмжээг ус ашиглуулах дүгнэлтийн мэдээллийг ашигладаг. Манай улс 2021 онд нийт 594.8 сая.м³/жил, 2022 онд 606.2 сая.м³/жил, 2023 онд 679.1 сая.м³/жил, 2024 онд 677.0 сая.м³/жил ус олборлож, ашигласан байна.

Улсын хэмжээнд жилд 677 сая шоометр ус ашиглаж байгаагийн 50 гаруй хувийг газрын доорх усаар хангаж байна. Нийт ус ашиглалтын 13.2% унд ахуйн хэрэглээнд, 48% хөдөө аж ахуйд, 6.7% эрчим хүчний үйлдвэрлэлд, 23.5% уул уурхайд, 8.6% үйлдвэр, ахуй үйлчилгээнд ашиглаж байна. Хамгийн их ус хэрэглээтэй мал аж ахуй, газар тариалан болон унд ахуй, эрчим хүч усны нөөц ашигласны төлбөрөөс чөлөөлөгдөж байна. Цаашид усны үнэ цэн, үнэлэмжийг нэмэгдүүлэх, хэмнэлт, үр ашиг бүхий зохистой ашиглалтыг дэмжих хүрээнд усны нөөцийн төлбөрийг тодорхой хувиар нэмэгдүүлэх бодлого баримтлан ажиллаж байна.

Хүн амын өсөлт, хотжилт, аж үйлдвэр, хөдөө аж ахуйн хөгжлийн хурдац, төлөвлөлтийг харгалзан гол ус хэрэглэгчдийн хэтийн төлөвийг тоймлон тооцож үзэхэд 2030 онд ус хэрэглээ 3-4 дахин нэмэгдэхээр төлөвтэй байна. Усны ойрын болон хэтийн хэрэглээг хангахад усны нөөцийн жигд бус тархалт, уур амьсгалын өөрчлөлт хүндрэл учруулахаар байна.

2021-2024 онд усны тоо бүртгэлийн дүн мэдээгээр нийт 2015 гадаргын усны эх үүсвэр хатаж, ширгэсэн байна. Цаашид усны температур нэмэгдэж, ууршилт ихсэж, урсац буурах хандлагатай байна. Ялангуяа говь хээрийн бүс байгалийн аясаар хуурайшиж, усны нөөцийг ууршилтаар алдаж байгаа нь усны хомстлыг бий болгож байна.

Монгол орны мөстөл, мөсөн голын талбай 1940-өөд онд 535 орчим, 1990 онд 470 орчим, 2002 онд 453.8, 2019 онд 338 км² болж эрчимтэй багасаж байна. Түргэн, Потанин, Цамбагарав, Сутай хайрхны мөстөл, мөсөн голын хайлалт 2050 оны үед 40-86% байж, дунджаар 65%-иар хайлах төлөвтэй байна.

Цэвдгийн тархалтын боломжит талбай сүүлийн 45 жилийн (1971-2016) хугацаанд Монгол орны цэвдгийн тархалтын боломжит талбайн хэмжээ 33.7%-аар буурсан болно. Мөн цэвдгийн өмнөд хил Хэнтийн нурууны хэсэгт 178км, Хангайн нурууны хэсэгт 94км хойш шилжсэн бол Алтай нурууны хэсэгт 240-900 м дээш шуугдсан байна. Монгол орны цэвдгийн талбай 2050 оны үед 33-61%-иар буурахаар төсөөлөгдөж байна.

Улсын хэмжээнд нийт хүн амын 83.6% баталгаат ундны усаар хангагдаж байна. Эх газрын эрс тэс уур амьсгалтай манай орны хувьд газрын доорх ус нь хамгийн найдвартай хамгаалагдсан эх үүсвэрт тооцогддог. Хүн амыг баталгаат ундны усаар хангахын тулд усны нөөцийн эрэл хайгуул хийж, нөөц тогтоон, ус хангамжийн эх үүсвэрийг байгуулах шаардлагатай байдаг. 2020-2024 онуудад улсын төсвийн хөрөнгөөр Өвөрхангай, Дорноговь, Өмнөговь, Говь-Алтай, Булган аймгийн 9 сум суурингийн хүн амын ус хангамжийн эх үүсвэрийг тогтоох газрын доорх усны хайгуул судалгаа хийж, нийт 236 л/с усны нөөцийг тогтоосон нь тогтвортой хөгжлийн зорилт болох шаардлага хангасан ундны усны эх үүсвэрээр хангагдсан хүн амын эзлэх хувийг нэмэгдүүлэхэд ихээхэн түлхэц болж байна.

Усны бодлогыг оновчтой тодорхойлох үндэс нь региональ судалгаа хийж газрын доорх усны нөөц баялгийг зөв тогтоох явдал юм. 2022-2024 онд гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг Дорноговь, Сүхбаатар, Өмнөговь, Дундговь, Дорноговь аймгийн нутагт хийж, нийт газар нутгийн 17.8 хувийг зураглалд хамруулж усны нөөцийн тойм мэдээлэлтэй болсон.

Монгол Улсын Засгийн газар ба АНУ-ын Мянганы сорилтын корпорац (МСК)-ын хооронд байгуулсан компакт гэрээний хөрөнгө оруулалтаар Улаанбаатар хотын нийт ус хангамжийг нэмэгдүүлэх хөтөлбөрийг 2021-2026 онд хэрэгжүүлж байна. Усны салбарын том хөрөнгө оруулалт болох уг хөтөлбөр амжилттай хэрэгжсэнээр Улаанбаатар хотын ус хангамжийг жилд 64 сая шоометрээр буюу 80 хувиар нэмэгдүүлж, нийслэл хотын хурдацтай өсөн нэмэгдэж байгаа усны эрэлт хэрэгцээг урт хугацаанд, тогтвортой хангах, эдийн засгийн ирээдүйн өсөлтийг дэмжих таатай нөхцөлийг бий болгох юм. Хөтөлбөрийн хүрээнд төв цэвэрлэх байгууламжаас гарах 50 мян.м³/хон хаягдал усыг дэвшилтэт технологиор дахин цэвэрлэж дулааны цахилгаан станцад нийлүүлэх Монгол Улсын хувьд анхны Ус дахин боловсруулах үйлдвэрийг байгуулж байгаа нь жилд 18 сая шоометр газрын доорх усны хэрэглээг хэмнэж, хаягдалгүй тойрог эдийн засгийн хөгжлийн бодит жишиг төсөл болно.

Монгол орны хур тунадасны улирлын шилжилт болж зуны хур бороо татрахын хамт эрчим нь ихсэх, өвлийн цасны хэмжээ нэмэгдэх хандлагатай байгааг харгалзан хаврын шар усны үер, зуны аадар борооны үерээс сэргийлэхийн зэрэгцээ үерийн усыг тогтоон хуримтлуулж гачиг үед хэрэглэх, үүнийг далан хаалт барьж их хэмжээний хөрөнгө зарахгүйгээр “Байгальд суурилсан шийдэл” буюу газрын тогтоц, голын голдирлын хэв шинжийг ашиглан татмын нуур, цувраа хөв цөөрөм байгуулахыг үр дүнд суурилсан төлөвлөлтөөр санхүүжилтийг баталгаажуулж хэрэгжүүлэх шаардлагатай байна.

Газрын тогтцыг ашиглан хөв цөөрөм байгуулах ажил тасралтгүй хийгдэж ирсэн бөгөөд 2023-2024 онд улсын төсвөөс гадна хөдөөгийн иргэдийн уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох чадавхыг бэхжүүлэх чиглэлээр хэрэгжүүлж байгаа төсөл, хөтөлбөрийн санхүүжилтээр бүтээн байгуулалтыг нэмэгдүүлж, Завхан, Ховд зэрэг аймгийн нутаг дэвсгэрт 256 мян.шоометр ус агуулах багтаамжтай 50 хөв цөөрөм байгуулсан байна. Харин газрын доорх усны нөөцийг хур тунадасны усаар зохиомлоор нэмэгдүүлэх, нөхөн сэргээх (MAR) арга технологийг нэвтрүүлэх үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай байна.

Гадаргын усыг хуримтлуулах, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, түүний нөлөөллийг бууруулах, ус хангамжийн эх үүсвэрийг гадаргын усаар шийдвэрлэх нөхцөлийг бүрдүүлж, суурьшлын бүс, үйлдвэр, дэд бүтэц, мал, амьтан, тэрбум мод болон үер уснаас хамгаалах, экосистемийн усны асуудлыг шийдвэрлэх зорилгоор Нэг сум-Нэг нуур буюу 333 нуур арга хэмжээг хэрэгжүүлэн ажиллахаар төлөвлөж, бүс нутгийн онцлогийг тусгасан зураг төсвийг боловсруулж байна. Ингэснээр 318 байршилд хөв цөөрөм байгуулах боломж бүрдэнэ.

Усны нөөцийг хамгаалах, экосистемийн доройтлоос сэргийлэх, усан орчны экосистемийг сайжруулах, цөлжилтийг бууруулах зорилгоор жил бүр булаг шандын эхийг хамгаалах, тохижуулах ажлыг орон нутгийн болон улсын төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлж байна. Улсын хэмжээнд 2024 онд нийт 293 булаг шанд, 3 рашааны эхийг хашиж хамгаалсан байна.

Усны бохирдлын гол эх үүсвэр нь ахуйн болон үйлдвэрлэлийн цэвэрлэх байгууламжаас стандартын шаардлага хангахгүй бохир усыг байгальд нийлүүлж байгаагаас мөн Улаанбаатар хот болон бусад суурин газруудын гэр хорооллын нүхэн жорлон, угаадасны нүхний ашиглалтаас үүсэж байна.

5.2. Усны газрын дотоод, гадаад орчны шинжилгээний үр дүн

5.2.1. Усны газрын ерөнхий чиг үүрэг, үндсэн чиг үүргийн хүрээнд орчны шинжилгээг гүйцэтгэж, шинжилгээний үр дүнг CBOT (Strengths, Weaknesses, Opportunities, Threats) хүснэгтэд нэгтгэн дор дурдсан байдлаар тодорхойлов.

Хүснэгт 2. Орчны шинжилгээний хүснэгт

ДОТООД ОРЧИН	
Давуу тал 1. Усны тухай хууль шинэчлэн батлагдаж, түүнд 2020 онд өөрчлөлт оруулан Усны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага буюу Усны газрын эрх үүргийг нарийвчлан тодорхойлж өгснөөр усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажлыг нэгдсэн зохион байгуулалтайгаар зохицуулах эрх зүйн үндэс бүрдсэн. 2. Улсын Их Хурлаас баталсан Алсын хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлого, Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, Монгол улсын хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт усны нөөцийн менежментийг хэрэгжүүлэхтэй холбогдсон цогц зорилт, арга хэмжээ тусгагдсан. 3. Мэдээллийн сан, мониторингийн багаж, төхөөрөмж бүхий хяналтын систем бий болж, дүгнэлтүүдийг цахимаар гаргаж эхэлсэн. 4. Хэлтэс, сав газрын захиргаа, албан хаагчид хоорондоо хамтран ажиллаж, мэдлэг, мэдээллээ харилцан солилцох, мэргэжил арга зүйгээр ханган ажиллах боломжтой. 5. Сав газрын түвшинд нутгийн захиргааны байгууллагуудын дунд зохицуулалт хийснээр усны нөөцийг хамгаалах ажилд санхүүжилт авах, салбарын ажлыг бусадтай хамтран гүйцэтгэх боломжтой.	Сул тал 1. Хайгуул судалгааны ажилтай холбоотойгоор Усны газарт хуваарилах санхүүжилт хангалтгүй байгаа нь газрын доорх усны нөөцийн хэмжээг бүрэн тогтоох боломжгүй байна. 2. Улсын төсөвт жил болгон 3-5 сумын төвийн усны эх үүсвэрийг тогтоох хайгуул судалгааны ажлын төсвийн төсөөллийг оруулж санал хүргүүлдэг ч улсын төсөвт хангалттай хөрөнгө хуваарилаагүй учраас хүн амыг найдвартай усаар хангах ажлыг зорилтод түвшинд хүргэх боломжгүй болох эрсдэлтэй. 3. Усны газар болон Байгаль орчин уур амьсгалын өөрчлөлтийн яамны чиг үүрэг давхцалтай байна. Усны тухай хуульд газрын доорх усны хайгуул судалгааг хийх, шийдвэр гаргах, нөөц батлах ажлыг яамны үндсэн чиг үүрэгт заасан ч газрын доорх усны хайгуул судалгааны төлөвлөгөөг боловсруулж хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг Усны газарт олгогдсон биелэлт тодорхой түвшинд саарч болзошгүй. 4. “Монгол ус” төрийн өмчит үйлдвэрийн газар татан буугдаж Усны хяналтын төв лабораторийг Усны газарт шилжүүлснээр чиг үүрэг нэмэгдэж, орон тоо, хүний нөөцийн дутагдал үүссэн. 5. Сав газрын захиргаадад усны хяналт-шинжилгээний тоног төхөөрөмж, программ хангамжийг нэмэгдүүлэх шаардлагатай. 6. Албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтууд өнөөгийн чиг үүрэгт нийцэхгүй болсон тул шинэчлэн боловсруулж батлуулах шаардлага үүссэн.

6. Усны газрын бүтэц зохион байгуулалтын хөтөлбөрийг шинэчлэн батлуулснаар албан тушаалын тодорхойлолтуудыг үйл ажиллагаандаа нийцүүлэн шинэчлэн боловсруулах нөхцөл бүрдсэн	7. Сав газрын захиргаад нь бүтэц, зохион байгуулалтын хувьд Усны газарт харьяалагддаггүй тул тэдгээрийг удирдлага, зохион байгуулалтаар хангахад хүндрэл учирдаг.
ГАДААД ОРЧИН	
1. Ашиглагч нь хамгаалах зарчмыг хэрэгжүүлэх хууль эрх зүйн орчин бүрдсэн. 2. Нэг сум-Нэг нуур /333 нуур/ хөтөлбөрийг Засгийн газар, салбарын яам, гадаад орнуудын хүрээнд дэмжиж, хэрэгжүүлэх шийдвэр гарсан. 3. Хөрш орнуудын хилийн усны хэлэлцээрийн үр дүн нэмэгдсэн 4. Төв цэвэрлэх байгууламжаас ирсэн хаягдал бохир усыг гүн боловсруулж дулааны цахилгаан станцын хэрэглээнд ашиглах боломж бүрдсэн. 5. Цахим системийн хөгжүүлэлт өргөжиж усны мэдээллийн системийг бусад цахим системтэй холбох нөхцөл бүрдсэн. 6. Хувийн хэвшил, төсөл хөтөлбөрийн санхүүжилтийг босгох боломж бүрдсэн 7. Гадаад орнуудын туршлага судлах, хүний нөөцийг чадавхжуулах нөхцөл бүрдсэн. 8. Улсын Их Хурлын 2024 оны 64 дүгээр тогтоолоор “Монгол улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал” батлагдсан	1. Агентлаг болон Сав газрын захиргаадын хүний нөөц, усны мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай 2. Усны хяналт-шинжилгээний сүлжээ хязгаарлагдмал, усны нөөцийн болон усны чанарын үзүүлэлтийг тогтмол хянах боломж дутагдалтай 3. Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн хэрэгжилт хангалтгүйн улмаас усны нөөцийг хамгаалах, нөхөн сэргээд хангалттай хөрөнгө оруулалт хийгддэггүй 4. Усны барилга байгууламжийн инженер, зураг, төсөв зохиох мэргэжлийн боловсон хүчин дутагдалтай 5. Усны салбарт хэрэгжүүлж буй төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэх мэргэжлийн байгууллага, аж ахуйн нэгжийн хүрэлцээ дутмаг 6. Хаягдал усны стандартын шаардлагад нийцэхгүй хаягдал усыг ихээр байгаль болон төв цэвэрлэх байгууламжид нийлүүлсний улмаас Туул гол болон бусад голуудын бохирдлын түвшин нэмэгдсэн 7. Төвлөрсөн бус ус хангамжийн эх үүрсвэрийн орчимд гэр хорооллын нүхэн жорлонгийн тоо хэт ихээр нэмэгдсэн нь хөрсний ус бохирдох нөхцөл бүрдсэн 8. Уур амьсгалын өөрчлөлтэй холбоотойгоор үер, ган, зуд бүхий эрсдүүд нэмэгдэх болсон

5.2.2. Усны газрын дотоод, гадаад орчны CВОТ шинжилгээний ерөнхий үнэлгээ:

Усны газрын үйл ажиллагаа нь хууль, эрх зүйн хувьд тодорхой суурь тавигдсан, бодлогын түвшинд дэмжлэгтэй, дотоод зохион байгуулалт бүхий бүтэцтэй байгууллага боловч гүйцэтгэлийн түвшинд санхүүжилт болон хүний нөөц, техник технологийн, сав газрын захиргаадын шууд удирдлага, хяналтын тогтолцоогүй зэрэг дутмаг байдал зонхилж байна.

Байгаль орчны уур амьсгалын өөрчлөлт, усны бохирдол, нөөцийн хомсдол зэрэг гаднын сөрөг нөхцөл байдал эрчимжиж байгаа энэ үед байгууллагын үйл ажиллагаа илүү инновац, технологид суурилсан, уялдаатай менежмент рүү шилжих шаардлагатай байна.

Дотоод орчны дүн шинжилгээний үнэлгээ:

Давуу талууд нь байгууллагад стратегийн боломж нээж байна. Тухайлбал хууль эрх зүйн орчин тодорхой түвшинд бий болсон, төрийн бодлогын дэмжлэгтэй, цахим хяналтын систем бий болсон байна.

Сул талууд нь голчлон нөөцийн хязгаарлалтад хамаарч байна. Үүнд санхүүжилт, хүний нөөц, тоног төхөөрөмжийн хомсдол, чиг үүргийн давхцал байна.

Гадаад орчны дүн шинжилгээний үнэлгээ:

Боломжууд нь олон улсын төсөл, бүсчилсэн бодлого, “Нэг сум–нэг нуур” хөтөлбөр, цахим системийн уялдаа, гадаад хамтын ажиллагаа, хаягдал ус дахин ашиглах технологи зэрэг нь шинэ хөрөнгө оруулалт татах ба усны менежментийг шинэ шатанд гаргах нээлттэй нөхцөл бий болж байна.

Аюул, эрсдэлүүд болох уур амьсгалын өөрчлөлт, бохирдол, усны хомсдол, мэргэжлийн хүний нөөцийн дутагдал нь усны нөөцийн тогтвортой байдлыг алдагдуулах эрсдэл үүсгэж байна.

5.2.3. Стратегийн тулгамдаж буй асуудал, чиг хандлага:

Усны нөөцийн хайгуул, мониторинг, хамгаалахтай холбоотой төсвийн хязгаарлалт нь үндсэн чиг үүргийн хэрэгжилтийг сааруулж байх тул санхүүжилтийн тогтолцоог бэхжүүлэх

Орон тоо болон мэргэжлийн албан хаагч, лабораторийн шинжээчдийн хүрэлцээ хангалтгүй байх тул хүний нөөцийг чадавхжуулах, бүтэц зохион байгуулалт шинэчлэх

Усны нөөцийн мониторингийн мэдээллийг төрийн бусад мэдээллийн сантай холбох шаардлагатай байгаа нь цахим системийн интеграц ба мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлж, усны мониторинг, мэдээлэл удирдлагыг цахимжуулж, дата-д суурилсан менежмент хэрэгжүүлэх

Уур амьсгалын өөрчлөлт, ган, үер зэрэгт урьдчилан бэлдэх тогтолцоо сул байх тул байгаль орчны эрсдэлд дасан зохицох бодлого хэрэгжүүлэх, усны эх үүсвэр, нуур, хөв цөөрөм, усан санг сэргээн хамгаалах ажлыг өргөжүүлэх

Усны нөөцийн менежментийг эрчим хүч, хөдөө аж ахуй, уул уурхай, үйлдвэржилт, хот төлөвлөлтийн бодлого, үйл ажиллагаатай уялдуулан хэрэгжүүлэх шаардлага үүссэн тул салбар хоорондын уялдааг хангаж төр, орон нутаг, хувийн хэвшил, иргэдийн хамтын оролцоонд тулгуурласан усны нөөцийн менежментийг хэрэгжүүлэхийн тулд Усны газрын чиг үүргийг өргөжүүлэн Ерөнхий газрын түвшинд зохион байгуулах шаардлагатай байна.

ЗУРГАА. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО

Монгол Улсын усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх, уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох тогтвортой усны менежментийн тогтолцоог бүрдүүлэх.

ДОЛОО. СТРАТЕГИЙН ЗОРИЛГЫГ ХЭМЖИХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ, СУУРЬ БОЛОН ЗОРИЛТОТ ТҮВШИН, СТРАТЕГИ

Усны газрын стратеги төлөвлөгөөг хууль тогтоомж, бодлогын баримт бичигт тусгагдсан салбарын зорилгыг хэрэгжүүлэх үндэсний хэмжээний стратегийг тусгахын зэрэгцээ бүс нутаг, нутаг дэвсгэрийн нэгжийн онцлогийг харгалзан үзэж үйл ажиллагааны уялдааг хангасан.

Стратеги төлөвлөгөөг боловсруулахад Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамны 2025-2028 оны стратеги төлөвлөгөө, “Алсын хараа-2050 Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлого”-д тусгасан усны нөөцтэй холбоотой үндсэн чиглэл, “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”-ийг баримтлан усны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээхтэй холбоотой чиг үүргийн хүрээнд дараах 11 зорилт, 49 арга хэмжээтэйгээр боловсруулж, төлөвлөв.

Долоо. Стратегийн зорилгыг хэмжих шалгуур үзүүлэлт, суурь болон зорилтот түвшин, стратеги

УСНЫ ГАЗРЫН 2025-2028 ОНЫ СТРАТЕГИ ТӨЛӨВЛӨГӨӨ

Бодлогын баримт бичигт тусгагдсан, болон үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэх зорилт	Стратеги /арга зам/	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Зорилтот түвшин					Санхүүгийн эх үүсвэр
			2024	2025	2026	2027	2028		
Ерөнхий чиг үүргийн нэр: Усны нөөцийг бохирдол, хомстлоос хамгаалах, зохистой ашиглах нэгдсэн менежментийг хэрэгжүүлж, салбар дундын зохицуулалтаар хангах									
Үндсэн чиг үүрэг-1: Усны нөөцийг судалж тогтоох, хамгаалах, нөхөн сэргээх, хуримтлуулах, усны нөөцийн эрэлт, нийлүүлэлтийг зохицуулах, хяналт тавих, сав газрын менежментийн тогтолцоог бэхжүүлж, усны мега төслийг хэрэгжүүлэх									
Зорилт-1.1. Усны нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, нэгдсэн менежментийг хэрэгжүүлэх	Арга хэмжээ 1.1.1. Улсын болон сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, усны аюулгүй байдлыг хангах;	Төлөвлөгөө боловсруулагдаж, хэрэгжилт эхэлсэн хувь	-	-	1	-	-	Улсын төсөв, төсөл хөтөлбөр	
	Арга хэмжээ 1.1.2. Ус ашиглах боломжит нөөцийн хэмжээг сав газрын түвшинд тогтоож, зориулалт бүрээр ашиглалт, хяналтын журмыг мөрдүүлэх;	Ус ашиглах боломжит нөөцийн хэмжээ тогтоогдсон сав газрын тоо	-	-	-	1	-	Улсын төсөв, төсөл хөтөлбөр	
	Арга хэмжээ 1.1.3. Гадаргын болон газрын доорх усны ашиглалтын дээд хязгаар /ус ашиглах боломжит нөөц/ тогтоосон дүгнэлт гаргах	Ирүүлсэн хүсэлтийн шийдвэрлэлтийн хувь	100	100	100	100	100	Төсөв шаардахгүй	
	Арга хэмжээ 1.1.4. Усны нөөцийн ашиглалтын байдалд үнэлгээ хийж, зохистой ашиглалтын хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх;	Усны нөөцийн зохистой ашиглалтын хөтөлбөр боловсруулсан тоо	-	-	1	-	-	Улсын төсөв, төсөл хөтөлбөр	
	Арга хэмжээ 1.1.5. Усны нөөцийн хамгаалалт, нөхөн сэргээлттэй холбоотой бодлого, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангах.	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	100	100	100	100	100	Улсын төсөв	
Зорилт-1.2. Усны нөөцийн судалгаа, тоо бүртгэл.	Арга хэмжээ 1.2.1. Усны хайгуул, судалгаа, зураг төсөл, төлөвлөгөө, ажлын даалгаврын хэрэгжилтэд хяналт тавих;	Хяналт тавьсан ажлын хувь	100	100	100	100	100	Төсөв шаардахгүй	

мэдээллийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх	Арга хэмжээ 1.2.2. Улсын усны тоо бүртгэл, статистикийн мэдээллийг нэгтгэн боловсруулж, үнэн зөв байдлыг хангах;	Мэдээллийн бүрдлийн хувь	100	100	100	100	100	Төсөв шаардахгүй
	Арга хэмжээ 1.2.3. Сав газрын хэмжээнд усны тоо бүртгэлийг жил бүр зохион байгуулж, холбогдох мэдээллийг нэгтгэх;	Тоо бүртгэлийн мэдээллийг санд оруулсан хувь	100	100	100	100	100	Улсын төсөв, орон нутгийн төсөв
	Арга хэмжээ 1.2.4. Усны мэдээллийн санг шинэчилж, цахим хэлбэрээр нэгдсэн мэдээллийн системд нэгтгэх;	Мэдээллийн цахим системд шилжүүлэх ажлын гүйцэтгэлийн хувь	-	20	50	100	100	Улсын төсөв, төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ 1.2.5. Хот, суурин газрын хүн амын ус хангамжийн эх үүсвэрийн нөөцийг тогтоох хайгуул, судалгааны ажлыг хийх	хайгуул, судалгааны ажлын тоо	96	101	103	105	109	Улсын төсөв, төсөл хөтөлбөр, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө
	Арга хэмжээ 1.2.6. Гидрогеологийн дунд масштабын зураглалын ажлыг өргөжүүлж, усны нөөцийн тархалтыг тогтоох	Зураглалыг хийсэн газар нутгийн хэмжээ, хувь	17.8	18.5	19.5	20.5	22	Улсын төсөв, төсөл хөтөлбөр, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө
Зорилт-1.3. Усны эдийн засгийн үнэлгээ, үнэ тариф, нөхөн төлбөрийн тогтолцоог боловсронгуй болгох	Арга хэмжээ 1.3.1. Усны экологи-эдийн засгийн үнэлгээний аргачлал, усны үнэ тариф тогтоох заавар боловсруулах;	Боловсруулсан зааврын тоо	-	-	1	-	-	Улсын төсөв, төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ 1.3.2. Усны нөөцөд учруулсан хохирлыг үнэлэх, нөхөн төлбөр тооцох;	Хохирол тооцсон хувь	100	100	100	100	100	Улсын төсөв
	Арга хэмжээ 1.3.3. Аж ахуйн нэгжийн илрүүлсэн усны нөөцийг хүсэлтийн дагуу бусад хэрэглээнд ашиглуулах нөхцөлд мэргэжлийн дүгнэлт гаргах;	Хүсэлтийг шийдвэрлэсэн хувь	100	100	100	100	100	Төсөв шаардахгүй
Үндсэн чиг үүрэг-2: Усны нөөцийг зохистой ашиглах бодлогын хэрэгжилтийг хангах, усны нөөцийн дахин ашиглалтыг нэмэгдүүлэх, ус хэмнэлтийг дэмжиж, мэргэжил арга зүйгээр хангах								
Зорилт-2.1. Ус ашиглалтын нэгдсэн мэдээлэл, тайлагнал, хяналтын тогтолцоог сайжруулах	Арга хэмжээ 2.1.1. Улсын хэмжээнд усны нөөц ашиглалтын тайланг жил бүр нэгтгэн гаргаж, усны нөөцийн тооцоо, ашиглалтын үр ашгийн үзүүлэлтүүдийг үнэлэх;	Тайлангийн тоо	2	4	6	8	10	Төсөв шаардахгүй
	Арга хэмжээ 2.1.2. Ус ашиглах дүгнэлт, зөвшөөрөл, гэрээний хэрэгжилтэд хяналт тавьж, ус ашиглагчдын хариуцлагыг сайжруулах;	Хяналт тавьсан тоо	280	290	300	310	320	Төсөв шаардахгүй
	Арга хэмжээ 2.1.3. Усны хэрэглээ, ашиглалтыг тоолууржуулах үйл ажиллагааг эрчимжүүлж, усны үр ашиг, хэмнэлтийг сайжруулах	Шинээр суурилуулсан тоолуурын тоо	1655	1680	1700	1720	1740	Улсын төсөв, төсөл хөтөлбөр, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө

	Арга хэмжээ 2.1.4. Усны нөөц ашигласны төлбөрийг хэрэглээний хэмжээнээс хамаарсан шатлан өсгөх зарчимд суурилж тогтоох, төлбөрийн орлогыг дахин хуваарилах эрх зүйн зохицуулалтыг бүрдүүлж хэрэгжүүлнэ.	Тогтоолд өөрчлөлт оруулсан байдал тоо	-	-	1	-	-	Улсын төсөв, төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ 2.1.5. Нэг сум-Нэг нуур "333 нуур" хөтөлбөрийг боловсруулан газрын тогтоц, голын голдирлын хэв шинжийг ашиглан хур тунадас, хайлсан цас, мөсний усыг хуримтлуулах цувраа хөв цөөрөм, далд усан сангууд байгуулна.	Хөв цөөрөм, усан сан байгуулсан газрын тоо	1	4	10	12	15	Улсын төсөв, төсөл хөтөлбөр, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө
	Арга хэмжээ 2.1.6. Аж ахуйн нэгж, байгууллагын байгаль орчин, нийгмийн хариуцлагын хүрээнд газрын доорх усны ордыг хур тунадасны усаар арвижуулж нөхөн сэргээх практикийг хэвшүүлнэ.	Газрын доорх хөв цөөрөм, усан сангийн тоо	1	2	5	10	15	Улсын төсөв, төсөл хөтөлбөр, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө
Зорилт-2.2. Ус ашиглалт, усны нөөцийн зохистой ашиглалт, дүгнэлт гаргалтыг боловсронгуй болгох	Арга хэмжээ 2.2.1. Гол, мөрний голдирол өөрчлөх, урсцад тохируулга хийх, усны барилга байгууламж барих, усны сан бүхий газрын ашиглалтын төсөлд мэргэжлийн дүгнэлт гаргах;	Хүсэлтийн дагуу дүгнэлт гаргасан хувь	100	100	100	100	100	Улсын төсөв
	Арга хэмжээ 2.2.2. Хоногт 100 м³-ээс дээш ус ашиглах, төвлөрсөн ус хангамжийн эх үүсвэр ашиглах, усан тээвэр, эрчим хүчний зориулалттай ус ашиглалтын дүгнэлт гаргах;	Хүсэлтийн дагуу дүгнэлт гаргасан хувь	100	100	100	100	100	Төсөв шаардахгүй
	Арга хэмжээ 2.2.3. Ган, хуурайшилт, усны нөөцийн бохирдол үүссэн үед тухайн сав газарт ус ашиглалт, хуваарилалтад хязгаарлалт тогтоох, усны ашиглалтыг тодорхой хугацаагаар түр хориглох шийдвэр гаргах;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	100	100	100	100	100	Төсөв шаардахгүй
	Арга хэмжээ 2.2.4. Ус ашиглалт, хэрэглээнд хэмнэлт, дахин ашиглалтыг нэмэгдүүлнэ.	Дахин ашигласан усны хэмжээ, хувь	65.7	68	70	72	74	Улсын төсөв, төсөл хөтөлбөр, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө
	Арга хэмжээ 2.2.5. Гол, горхи, булаг, шанд, рашааны ундаргын эхийг хамгаалах ажлыг эрчимжүүлэх	Хашиж хамгаалсан булаг, шандын тоо	3980	4100	4220	4340	4460	Улсын төсөв, төсөл хөтөлбөр, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө

Үндсэн чиг үүрэг-3: Газрын доорх усны нөөц, чанарын хяналт шинжилгээ, гадаргын болон газрын доорх усны итгэмжлэгдсэн лабораторийн шинжилгээ хийх, усны бохирдлыг бууруулах, ус бохирдуулсны төлбөрийн тухай тухай хуулийг хэрэгжүүлэх, нэгдсэн удирдлагаар хангах замаар усны нөөцийг хомстож, бохирдохоос сэргийлэх								
Зорилт-3.1. Усны нөөц, чанарын төлөв байдлыг судлах, хянах, усны хяналтын төв лабораторийн тасралтгүй хэвийн ажиллагааг хангах	Арга хэмжээ 3.1.1. Усны нөөц, горим, чанарын төлөв байдал, өөрчлөлтөд байнгын ажиглалт, хэмжилт, судалгаа шинжилгээ хийж, үнэлгээ өгөх, мэдээллээр хангах зорилго бүхий усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээг зохион байгуулах;	Усны хяналт-шинжилгээний нэгдсэн сүлжээний тоо	325	331	350	370	390	Улсын төсөв, төсөл хөтөлбөр, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө
	Арга хэмжээ 3.1.2. Усны чанарыг бохирдлын индексээр үнэлж, үр дүнг хяналт-шинжилгээний мэдээллийн сангаар дамжуулан төр, хувийн хэвшил, иргэдэд нээлттэй хүргэх;	Усны чанарын мэдээллийг индексээр үнэлж, нийтэд жилд мэдээлсэн тоо	-	1	2	2	2	Төсөв шаардахгүй
	Арга хэмжээ 3.1.3. Усны хяналтын төв лабораторийн тасралтгүй үйл ажиллагааг хангаж, лабораторийн шинжилгээний чанарыг сайжруулан, усны бохирдлыг бууруулах суурь мэдээлэл бүрдүүлэх;	Хэрэгжүүлсэн ажлын тоо	2	2	2	2	2	Улсын төсөв
Зорилт-3.2. Ус бохирдлыг бууруулах, хаягдал усны хэмжээнд хяналт тавин хариуцлагыг сайжруулах	Арга хэмжээ 3.2.1. Хаягдал ус хаях, зайлуулах зөвшөөрлийг хоногт 50 шоо метрээс дээш хаягдал ус гаргадаг, эсхүл аюултай бодис агуулсан байгууллагад хаягдал усны дүгнэлт гаргах;	Төлбөр төлөгч аж ахуйн нэгжийн тоо	3300	3500	3700	3900	4100	Төсөв шаардахгүй
	Арга хэмжээ 3.2.2. Ус бохирдуулсны төлбөр, зөвшөөрөл олгох үйл явцаар дамжуулан үйлдвэрлэлийн усны дахин ашиглалт, үр ашгийг нэмэгдүүлж, усны үл мөрийг бууруулна;	Дахин ашигласан усны хэмжээ, хувь	78	79	80	81	82	Улсын төсөв, төсөл хөтөлбөр, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө
	Арга хэмжээ 3.2.3. Хаягдал ус дахин боловсруулах, цэвэрлэсэн усыг дахин ашиглах үйл ажиллагааг дэмжин хөгжүүлнэ.	Шинэчлэн боловсруулсан хууль тогтоомж, норм, стандартын тоо	2	2	1	1	1	Улсын төсөв, төсөл хөтөлбөр, орон нутгийн төсөв, хувийн хэвшлийн хөрөнгө
	Арга хэмжээ 3.2.4. Усны сан бүхий газар болон ундны усны эх үүсвэрийн хамгаалалтын бүсэд хог хаягдлыг булшлах, устгах байгууламж байгуулахыг	Хяналт тавин, санал хүргүүлсэн тоо	-	-	1	1	1	Төсөв шаардахгүй

	хориглосон шийдвэрийн мөрдөлтөд хяналт тавих;							
	Арга хэмжээ 3.2.5. Үйлдвэрлэл, үйлчилгээ эрхэлж байгаа иргэн, аж ахуйн нэгж, байгууллагуудын урьдчилан цэвэрлэх байгууламж болон ахуйн бохир усны бага хүч чадлын цэвэрлэх байгууламжаас гарч байгаа хаягдал усны стандартын шаардлагыг хангуулах, хяналт шалгалт хийх	Хяналт, шалгалт хийсэн тоо	3	6	7	8	9	Улсын төсөв
	Арга хэмжээ 3.2.6. Ганга, Өгий нуур, Хэрлэн голыг бохирдолт, ширгэлтээс хамгаалах урсцыг сайжруулах, нөхөн сэргээх төсөл хэрэгжүүлэх	Ганга нуурын төслийн хэрэгжилтийн хувь	50	97	100	-	-	Улсын төсөв, төсөл хөтөлбөр
		Өгий нуурын төслийн хэрэгжилтийн хувь	50	75	100	-	-	Улсын төсөв, төсөл хөтөлбөр
		Хэрлэн голын төслийн хэрэгжилтийн хувь	ТЭЗҮ-д тодотгол хийх гүйцэтгэгчтэй гэрээ байгуулсан	ТЭЗҮ, зураг төслийн ажлыг эхлүүлнэ	ТЭЗҮ, зураг төсөл боловсруулсан байна	Тендер сонгон шалгаруулах ажлыг эхлүүлнэ	Төслийн ажлыг эхлүүлнэ	Улсын төсөв, төсөл хөтөлбөр
Үндсэн чиг үүрэг-4: Салбарын нэгдсэн удирдлага, зохион байгуулалтыг хангаж, үйл ажиллагааны менежмент, хүний нөөц, гадаад хамтын ажиллагаа, санхүү, хөрөнгө оруулалт, хууль эрх зүй, бодлого, хөтөлбөрийн хэрэгжилт, цахимжилт, дотоод хяналт, шинжилгээ болон төрийн албан хаагчийн сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг сайжруулах								
Зорилт-4.1. Усны нөөцийн мэдээллийн нэгдсэн менежментийг сайжруулах	Арга хэмжээ 4.1.1. Улсын усны мэдээллийн цахим санг бүрдүүлэх, хөтлөх, шинэчлэх үйл ажиллагааг зохион байгуулах;	Мэдээллийг санд оруулсан хувь	0	20	50	100	100	Төсөв шаардахгүй
	Арга хэмжээ 4.1.2. Усны мэдээллийг олон нийт, байгууллагад нээлттэй хүргэх, нээлттэй өгөгдлийн хүртээмжийг нэмэгдүүлэх;	Мэдээллийн ил тод байдлын шалгуурын хувь	30	70	90	100	100	Төсөв шаардахгүй
	Арга хэмжээ 4.1.3. Мэдээллийн системийн найдвартай, аюулгүй, тасралтгүй ажиллагааг хангах, мэдээллийн дэд бүтцийг шинэчлэх;	Систем шинэчлэх ажлын гүйцэтгэлийн хувь	50	70	100	100	100	Улсын төсөв, төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ 4.1.4. Цахим үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах замаар үйл ажиллагааг цахимжуулах;	Цахимжуулах ажлын гүйцэтгэлийн хувь	50	70	100	100	100	Улсын төсөв, төсөл хөтөлбөр
Зорилт-4.2. Усны салбарын мэргэжил, арга	Арга хэмжээ 4.2.1. Ус ашиглагч, хэрэглэгч, хангагч байгууллагуудад мэргэжил, арга зүйн нэгдсэн зөвлөгөө, чиглэл өгөх;	Зөвлөгөө, ажлын чиглэлийн тоо	280	290	300	310	320	Төсөв шаардахгүй

зүйн удирдлагыг бэхжүүлэх	Арга хэмжээ 4.2.2. Сав газрын захиргаа, аймаг, нийслэлийн байгаль орчны алба, сум, дүүргийн байгаль хамгаалагч, улсын байцаагч нарт усны чиглэлээр сургалт, чадавхжуулах арга хэмжээг хэрэгжүүлэх;	Сургалт, чадавхжуулах арга хэмжээний тоо	6	10	16	26	36	Улсын төсөв, төсөл хөтөлбөр
	Арга хэмжээ 4.2.3. Усны салбарын мэргэжилтнүүдийн мэдээлэл солилцооны тогтолцоог сайжруулах;	Зохион байгуулсан ажлын тоо	-	1	2	3	4	Төсөв шаардахгүй
Зорилт-4.3. Байгууллагын бодлого, төлөвлөлт, санхүүгийн удирдлагыг сайжруулах	Арга хэмжээ 4.3.1. Төрийн бодлого, хууль тогтоомж, хөтөлбөрийн хэрэгжилтийг хангаж, үнэлэх;	Гүйцэтгэлийн хувь	90	92	95	98	100	Төсөв шаардахгүй
	Арга хэмжээ 4.3.2. Төсвийн шууд захирагчийн төсөв, хөтөлбөрийг үр дүнтэй төлөвлөж, хэрэгжилтэд хяналт тавих;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	100	100	100	100	100	Төсөв шаардахгүй
	Арга хэмжээ 4.3.3. Байгууллагын хөрөнгө оруулалт, бүтээгдэхүүн нийлүүлэлт, төсвийн зарцуулалтыг ил тод, үр ашигтай байлгах;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	100	100	100	100	100	Төсөв шаардахгүй
	Арга хэмжээ 4.3.4. Байгууллагын өмч, эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, бүртгэл хяналтыг сайжруулах, өргөтгөл шинэчлэл хийх;	Холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийн хувь	100	100	100	100	100	Төсөв шаардахгүй
Зорилт-4.4. Хүний нөөцийн чадавх, албан хаагчийн нийгмийн баталгааг сайжруулах	Арга хэмжээ 4.4.1. Хүний нөөцийн бодлого, төлөвлөлт боловсруулж, хэрэгжилтийг хангах;	Боловсруулсан хөтөлбөрийн гүйцэтгэлийн хувь	-	1	1	-	-	Төсөв шаардахгүй
	Арга хэмжээ 4.4.2. Төрийн албан хаагчдыг тогтвортой ажиллах нөхцөлөөр хангах, үр дүнгийн урамшууллын тогтолцоог боловсронгуй болгох;	Хөтөлбөрийн гүйцэтгэлийн хувь	100	100	100	100	100	Улсын төсөв
	Арга хэмжээ 4.4.3. Мэргэшүүлэх сургалт, хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлж, салбарын мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх;	Мэргэшүүлэх сургалтад хамрагдсан хувь	40	50	55	60	65	Улсын төсөв
	Арга хэмжээ 4.4.4. Албан хаагчдын нийгмийн баталгаа, эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдлын орчныг сайжруулах;	Хөтөлбөрийн гүйцэтгэлийн хувь	100	100	100	100	100	Улсын төсөв

---oOo---

НАЙМ. СТРАТЕГИЙН ЗОРИЛГО БА УСНЫ ГАЗРЫН НЭГЖ, БАЙГУУЛЛАГЫН БҮТЦИЙН УЯЛДАА, ЗУРАГЛАЛ

Засгийн газрын 2020 оны 4 дүгээр сарын 01-ний өдрийн 121 дүгээр тогтоолоор “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг-Усны газар” байгуулагдаж, “Засгийн газрын агентлагийн бүтэц, орон тооны талаар хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай” Засгийн газрын 2025 оны 52 дугаар тогтоолоор Усны газрын орон тоог 3 орон тоогоор бууруулж 35 орон тоотой байхаар тогтоосны дагуу “Усны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг өөрчлөн батлах тухай” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/691 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар “Усны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”, 2 дугаар хавсралтаар “Усны газрын зохион байгуулалтын бүтэц”-ийг тус тус баталсан.

Тус бүтэц, зохион байгуулалтын хүрээнд Усны газар нь Агентлагийн дарга болон захиргаа, санхүүгийн асуудал хариуцсан Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, усны нөөц, төлөвлөлтийн асуудал хариуцсан Усны нөөцийн менежмент, төлөвлөлтийн хэлтэс, усны ашиглалт, үйлдвэр техникийн асуудал хариуцсан Ус ашиглалт, технологийн хэлтэс, усны чанар, хяналт шинжилгээний асуудал хариуцсан Усны чанар, шинжилгээний хэлтэс гэсэн 4 нэгжтэйгээр ажиллаж байна. Мөн сав газрын усны нөөцийн нэгдсэн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлж, орон нутагт салбар дундын зохицуулалтыг хангах үндсэн чиг үүрэгтэй 21 сав газрын захиргааг мэргэжил, арга зүйгээр удирдан ажиллаж байна.


Усны газар нь 35 албан хаагчийн бүрэлдэхүүнтэй агентлаг байхаар батлагдсаны дагуу “Орон тоо, албан тушаалын жагсаалт, цалингийн санг шинэчлэн тогтоох тухай” Усны газрын даргын 2025 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн А/145 дугаар тушаалаар бүтцийн өөрчлөлтийг хийж, төрийн захиргааны албаны тушаалаас төрийн үйлчилгээний албан тушаалын ангилалд шилжин томилогдсон албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг шинэчлэн болон шинээр боловсруулж баталсан.

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/691 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар батлагдсан “Усны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”-т зааснаар агентлагийн үйлчлүүлэгч буюу хэрэглэгчийн бүлгийг тодорхойлж, бүтцийн схем 1-т тусгалаа.

Мөн тушаалын 2 дугаар хавсралтаар батлагдсан “Усны газрын зохион байгуулалтын бүтэц”-ийг бүтцийн схем 2-тус тус оруулсан.


Усны газрын стратегийн удирдлага, зохицуулалтын хэрэгцээний эх үүсвэр

(Бүтцийн схем 1)



Усны газрын бүтэц, зохион байгуулалт (Бүтцийн схем 2)

УСНЫ ГАЗРЫН ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН БҮТЭЦ



ЕС. ХАВСРАЛТ

1. “Усны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр болон зохион байгуулалтын бүтцийг өөрчлөн батлах тухай” Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн сайдын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А/691 дүгээр тушаалын 1 дүгээр хавсралтаар “Усны газрын үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр”, 2 дугаар хавсралтаар “Усны газрын зохион байгуулалтын бүтэц”-ийг тус тус хавсаргав.

ТОВЧИЛСОН НЭРИЙН ТАЙЛАЛ

АЭБТХ	Агентлагийн эрх зүйн байдлын тухай хууль
БНХАУ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
НМИТБТХ	Нийтийн мэдээллийн ил тод байдлын тухай хууль
ОХУ	Оросын Холбооны Улс
ТАТХ	Төрийн албаны тухай хууль
УБТТХ	Ус бохирдуулсны төлбөрийн тухай хууль
УТХ	Усны тухай хууль
ҮЧҮ	Үндсэн чиг үүрэг
ХЗТХ	Хэмжил зүйн тухай хууль
ХХТХ	Хог хаягдлын тухай хууль